

**АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ТАНИЛЦУУЛГА**

2026.02.02

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.24-т “Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ” гэж, мөн 2021 оны “Шинэ сэргээлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын Аж үйлдвэржилтийн сэргээлтийн 3.1-т “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан хөрөнгө оруулалт шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулна” гэж тус тус заасан.

Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-ыг үндэслэн баталсан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгож байна. Монгол Улсын хэмжээнд 2018-2025 онд нийт 5.7 сая га талбайд хамаарах 1106 хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сонгон шалгаруулалт зарлаж, 2.7 сая га талбай бүхий 589 хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон байна. Нийт сонгон шалгаруулалтын амжилттай болсон хувь тусгай зөвшөөрлийн тоогоор 53.2%, талбайн хэмжээгээр 47.4% байна.

Мөн энэ хугацаанд зарим аж ахуйн нэгжүүд сонгон шалгаруулалтад өндөр үнийн санал ирүүлсэн боловч үнийн саналын зөрүүг төлөөгүйн улмаас сонгон шалгаруулалт хүчингүй болж байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг 2022 оноос бүрэн цахим хэлбэрт шилжүүлсэн бөгөөд нийт 313 талбайн цахим сонгон шалгаруулалтын явцад 87 талбайд өндөр үнийн санал ирүүлэн, холбогдох төлбөрийг төлөлгүй сонгон шалгаруулалт амжилтгүй болсон нь 27.8 хувь болж байна.

Энэ нь ашигт малтмалын орд нээгдэх боломж бүхий зарим хэтийн төлөвтэй талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулалттайгаар амжилтгүй болгож, тухайн талбайг зарлах хугацааг хойшлуулдаг гэх салбарынхны дунд хардлага үүсгээд байна.

Дээрх нөхцлийг Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.6-д заасны дагуу сонгон шалгаруулалтад шалгарсан ч мэдэгдэлд заасан төлбөрийг төлөөгүй оролцогчийн босго үнийг буцаан олгохгүй байгаа нь асуудлыг шийдвэрлэж чадахгүй байна.

Монгол Улсын хэмжээнд 2025 онд олгосон нийт хайгуулын тусгай зөвшөөрлийн 33% гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд байна. Мөн өндөр үнийн санал ирүүлэн сонгон шалгаруулалтад шалгарсан аж ахуйн нэгжүүдийн 50 орчим хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан аж ахуйн нэгжүүд байгаа нь салбарын болон дотоодын аж ахуйн нэгжүүдэд хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлэх шаардлагатайг харуулж байна.

Дээрх асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд дараах өөрчлөлтүүдийг оруулахаар боловсруулж байна. Үүнд:

1. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогч үнийн саналын зөрүүг төлөөгүйн улмаас сонгон шалгаруулалт амжилтгүй болсон тухайн талбайг шинээр зарлагдах дараагийн сонгон шалгаруулалтын урилгад дахин нийтэлэх,
2. Монгол Улсад тогтвортой үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор тухайн аж ахуйн нэгжийн насжилт болон татварын тайлан илгээсэн байдлаар техникийн саналд үнэлгээ өгөх зохицуулалтыг бий болгох,
3. Үнийн болон техникийн саналын үнэлгээний харьцааг 50/50 хувь байх.

Журамд нэмэлт, өөрчлөлт орсноор сонгон шалгаруулалтын талбайд өндөр үнийн санал ирүүлэн шалгарсан этгээд зөрүүг төлөхгүй байх, тодорхойгүй хугацаагаар хойшлуулдаг асуудлыг шийдвэрлэх боломжтой юм.

ГЕОЛОГИЙН БОДЛОГЫН ГАЗАР

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-д дор дурдсан агуулга бүхий заалтыг нэмсүгэй.

1.1. 4.5. Шалгарсан оролцогч нь Ашигт малтмалын тухай хуулийн 20.5.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд тухайн талбайг хамгийн эхний шинээр зарлах сонгон шалгаруулалтын урилгад нийтэлнэ.

2. Журмын холбогдох заалтуудыг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

2.1. 3.1.1. хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчид 50 (тавин) оноо бусад оролцогчдын ирүүлсэн үнэ бүрийг цахим системд илгээсний дагуу хамгийн өндөр үнэтэй харьцуулж доорх томъёогоор тооцоолно;

Бусад оролцогчийн үнийн санал

Бусад оролцогчийн үнийн саналын оноо = ----- х 50

Хамгийн өндөр үнийн санал

2.2. 3.1.2. оролцогчийн үнийн саналын үнэлгээний үр дүнг цахим систем автоматаар тухайн сонгон шалгаруулалтад оролцож буй оролцогчдод мэдээлэх бөгөөд комиссын нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтлөн комиссын дарга, гишүүдэд танилцуулна.

2.3. 3.2.2. оролцогчдоос ирүүлсэн техникийн саналыг (Журмын 4 дүгээр хавсралт)-т заасны дагуу үнэлнэ;

3. Сонгон шалгаруулалтын журмын 3.1.3, 3.2.3 дахь заалтуудыг хассугай.

3. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын сайдын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын 4 дүгээр хавсралтыг шинэчлэн баталсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Өнөр насан/-т даалгасугай.

САЙД

Г.ДАМДИННЯМ

**АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТЕХНИКИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭ**

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ
	Төслийн техникийн баримт бичгийн үнэлгээ /нийт/	2-50
1	Талбайн геологи, хайгуулын ажлын төлөвлөлт /3 жилээр/	0-10
	Геологи, хайгуулын ажлыг оновчтой, гүйцэд төлөвлөсөн: Талбайн геологийн тогтцыг бүрэн судалж, байж болох бүх төрлийн ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ өгсөн байх, арга аргачлалд судалгааны ажил зохимжтой зөв төлөвлөгдсөн байх.	7-10
	Геологи хайгуулын ажил төлөвлөсөн: Талбайн геологийн тогтцыг гүйцэт судлаагүй, хайгуулын шатны ажлуудыг ерөнхийд нь төлөвлөсөн байх.	4-6
	Геологи, хайгуулын ажлын төлөвлөлт хангалтгүй: Хайгуулын талбайн мэдээлэлтэй бүрэн танилцаагүй, судалгааны ажлын зорилго тодорхой бус, төлөвлөсөн хайгуулын ажлын арга, аргачлал, ажлын хэмжээ оновчтой бус.	0-3
2	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажил, зардлын хэмжээ, хэрэгжүүлэх хугацааг тооцсон төлөвлөлт, мэдээлэл	0-5
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилыг бодитой, бүрэн хангалттай төлөвлөсөн: Хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн уулын малталт, өрөмдлөгийн ажлын хэмжээнд төлөвлөсөн зардал хангалттай төлөвлөгдсөн байх.	5
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилыг алдаатай төлөвлөсөн байх: Хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн уулын малталт, өрөмдлөгийн ажлын хэмжээнд төлөвлөсөн зардал хангалтгүй, дутуу төлөвлөгдсөн байх.	3-4
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилыг бодитой төлөвлөсөн /бүрэн хангалтгүй төлөвлөсөн: Хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн уулын малталт, өрөмдлөгийн ажлын хэмжээнд буруу төлөвлөсөн зардал хангалтгүй байх.	0-2
3	Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал болон тэдгээрийн туршлага чадвар	1-10
3.1	Мэргэжлийн боловсон хүчний туршлага, чадвар	1-5
	Монгол Улсын Зөвлөх геологич ажилладаг	5
	Монгол Улсын Мэргэшсэн геологич ажилладаг	3
	Аль аль нь байхгүй Мэргэжлийн геологич ажилладаг	1
3.2	Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал	0-5
	Төслийг гүйцэтгэх өөрийн үндсэн ажилтантай буюу ИТА болон Геологич 100 хувь хангагдсан эсэх (НДШ төлөлтийн тодорхойлолт, бусад нотолгоотой байх).	5
	Төслийг гэрээгээр гүйцэтгүүлэх бол (ИТА болон Геологичид <99 хувь).	3
	Алдаатай, материал дутуу ирүүлсэн	0
4	Төсөлд ажиллах техник тоног төхөөрөмжийн мэдээллийн үнэлгээ (Гэрээ болон хавсралтаар баталгаажсан байна.)	1-5

	Геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өөрийн өмчийн өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан бол (<i>өрөм, геофизикийн багажийг нотлох хавсралтууд баримт бичиг</i>)	5
	Геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрөм, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжийг түрээсэлдэг эсвэл гэрээгээр хайгуулын ажил гүйцэтгүүлэх бол (<i>Түрээсийн болон хамтран ажиллах гэрээ</i>)	3
	Геологи, хайгуулын ажил гүйцэтгэх техник тоног төхөөрөмжийн мэдээлэл ирүүлээгүй болон алдаатай, дутуу ирүүлсэн бол.	1
5	Монгол Улсад тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан эсэх	0-10
	Монгол Улсад 10 болон түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулсан.	10
	Монгол Улсад 6-9 жил үйл ажиллагаа явуулсан.	6-9
	Монгол Улсад 3-5 жил үйл ажиллагаа явуулсан.	3-5
	Монгол Улсад 1-2 жил үйл ажиллагаа явуулсан.	0
6	Тогтвортой татвар төлөгч эсэх (<i>Татварын тайлангаар баталгаажуулсан байна.</i>)	0-10
	Сүүлийн 3 жил тогтвортой орлоготой тайлан өгсөн	10
	Сүүлийн 3 жил тогтмол тайлан өгсөн	5
	Сүүлийн 3 жил тайлан өгсөн ч Х тайлан	1
	Сүүлийн 12 сар тайлангүй	0
НИЙТ ОНОО		50

---oOo---